



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот


「 Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн
ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 23 дугаар зүйл, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Нийслэл Улаанбаатар хотын 380 жилийн түүхт ойн баярыг 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг Удирдан зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ойн баярыг тэмдэглэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, шаардагдах хөрөнгийг нийслэлийн төсөвт тусгаж, нийслэлийн төр захиргааны байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн бүтээлч санал санаачилгыг өрнүүлэн шаардлагатай арга хэмжээ авч, хэрэгжүүлж ажиллахыг Зохион байгуулах хорооны дарга /С.Батболд/-д даалгасугай.


ДАРГА



С.АМАРСАЙХАН

1110100094

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар сарын 23-ны
өдрийн 29 дугаар тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН 380 ЖИЛИЙН
ОЙН АРГА ХЭМЖЭЭГ НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч;
- Орлогч дарга: Нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан
төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч;
- Гишүүд: Нийслэлийн Засаг даргын Дэд бүтэц, гэр хорооллын
хөгжлийн асуудал хариуцсан орлогч;
- Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын
бохирдлын асуудал хариуцсан орлогч;
- Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал
хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг
даргын орлогч;
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчид; /зөвшилцсөнөөр/
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгчид; /зөвшилцсөнөөр/
- Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд
Захирагчийн ажлын албаны дарга;
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга;
- Дүүргүүдийн Засаг дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
Захиргааны удирдлагын хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн
Штабын дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
хөгжлийн хэлтсийн дарга;

